



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 07 өдөр

Дугаар 4/195

Бат-Өлзий сум


Г Дуудлага худалдаа зохион байгуулах  
ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйл, Ойн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, "Хуш модны самар бэлтгэх хэмжээ тогтоох тухай" Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн A/723 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хуш модны самрыг бэлтгэх тусгай зөвшөөрлийг олгох дуудлага худалдаа зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар, үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх хуш модны самрын багцын хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай

2.Үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх, тээвэрлэх хуш модны самрын тусгай зөвшөөрлийг олгох дуудлага худалдааг хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, дуудлага худалдааны тайлан мэдээг тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч Сум дундын ойн ангийн дарга (Д.Очирхуяг)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.



Сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар  
сарын 07-ны өдрийн А/195 дугаар  
захирамжийн нэгдүгээр дүгээр хавсралт

### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Д.Очирхуяг ( Сум дундын ойн ангийн дарга)

Гишүүд: Ц.Батгэрэл (Байгаль орчин, аялал жуулчлалын  
газрын Биологийн төрөл зүйл, мэдээллийн сан  
хариуцсан мэргэжилтэн)

А. Мягмардагва (Сум дундын ойн ангийн инженер)  
Б.Янжиндулам ( Байгаль орчны асуудал хариуцсан  
мэргэжилтэн )

Б.Пүрэвсүрэн (Засаг даргын Тамгын газрын нягтлан  
бодогч)

Д.Золзаяа (Сум дундын ойн ангийн нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга: Ш.Бумандолгор (Сум дундын ойн ангийн инженер)

---оо---

Сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар  
сарын 07-ны өдрийн А/195 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОРИУЛАЛТААР ХУШ МОДНЫ САМРЫН ДУУДЛАГА ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/737 дугаар тушаалд заасны дагуу дэнчин төлж бүртгүүлсэн аж ахуй нэгж, байгууллага түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд Хуш модны самрыг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх.

Зөвшөөрлийн дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулах ажлын хэсгийн үйл ажиллагааг энэхүү удирдамжаар зохицуулна.

1.2. Үйлдвэрлэлийн зориулалтаар зөвшөөрлийн дуудлага худалдаа (цаашид “дуудлага худалдаа” гэх)-г зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, дуудлага худалдааны удирдамжийг Сумын Засаг дарга батална.

1.3. Тус удирдамжийн 1.2-т заасан ажлын хэсэгт төлөөлөл багтсан 5-9 гишүүнтэй байна. (цаашид “ажлын хэсэг” гэх). Гишүүн тус бүрийн үүрэг хариуцлагыг ажлын хэсгийн дарга чиглүүлж өгнө.

1.4. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын сайдын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/737 дугаар тушаалаар батлагдсан ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах, журамд заасны дагуу Хуш модны самрыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх зөвшөөрлийг дуудлага худалдааны журмаар зохион байгуулах, эхлэх босго үнийн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын баталсан ойн дагалт баялгийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээний 50 хувиар тооцно хэмжээг дуудлага худалдааны анхны үнийн санал гэж тооцно.

1.5. Дуудлага худалдааг зохион байгуулахдаа “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журмыг мөрдэж ажиллах ба тус журмын 4.3-т заасны дагуу нээлттэй мэдээлж, шийдвэр гарснаас 7 хоногийн дотор олон нийтэд нээлттэй мэдээлж, ажлын 14 хоногийн дотор цахим хэлбэрээр зохион байгуулах.

1.6. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын тушаалаар батлагдсан дээд хэмжээнээс хэтрүүлж зөвшөөрөл олгохгүй байх.

1.7. Улсын тусгай хамгаалалттай газар нутгаас иргэдэд зөвхөн ахуйн зориулалтаар түүх зөвшөөрөл олгох.

1.8. Байгалийн нөөц ашиглах төлбөрөөс орсон орлогын 85 хувийг “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэхь заалтын дагуу зөвхөн Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулна.

1.9. Сумын засаг дарга дуудлага худалдааны орлогын 20-иос доошгүй хувийг нөөцийн судалгаа хийх, нөөцийг бэлтгэх талбайн зураглал гаргах, ашиглалтад хяналт тавих арга хэмжээг санхүүжүүлж, шийдвэрлэн ажиллах.

### Хоёр. Дуудлага худалдаа зохион байгуулахад баримтлах зарчим

2.1. Дуудлага худалдааг зохион байгуулахад дараах зарчмыг баримтална.

2.1.1. Дуудлага худалдаанд үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх хэмжээг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын тушаалаар баталсан тооноос хэтрүүлэхгүй байх;

2.1.2. Унийн саналаа ээлж дараалан тодорхой алхамтайгаар өсгөх;

2.1.3. нээлттэй, ил тод байх;

2.1.4. тэгш, шударга оролцоог хангасан байх.

Гурав. Дуудлага худалдааны хэлбэр, дуудлага худалдаа явуулах дараалал

3.1. Дуудлага худалдааг цахимаар цаашид (программ гэх) ашиглан нээлттэй, ил тод зохион байгуулна.

3.2. Дуудлага худалдааг дараах дарааллын дагуу явуулна:

3.2.1. дуудлага худалдааны бэлтгэл ажлыг хангах;

3.2.2. дуудлага худалдааг зарлан мэдээлэх;

3.2.3. дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх;

3.2.4. дуудлага худалдааг явуулах;

3.2.5. дуудлага худалдааны ялагчийг зарлаж, ялагч, тухайн ажлын хэсэгтэй турвалсан гэрээ байгуулах.

#### **Дөрөв. Дуудлага худалдааны бэлтгэл ажлыг хангах**

4.1. Тус удирдамжийн 1.3-д заасны Сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг дуудлага худалдааг зохион байгуулахтай холбогдуулан дор дурдсан бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэнэ:

4.1.1. Дуудлага худалдаагаар хуш модны самрын нөөц, ургац гэх мэт үзүүлэлт хэрэгжилтийн үр дүнгийн мэдээллийг боловсруулсан байна;

4.1.2. Дуудлага худалдааны тов, Хуш модны самрын хуваарь, багц, дуудлага худалдааны анхны үнэ, дуудлага худалдааны зохион байгуулалт, хэлбэр, хугацаа, дэнчингийн хэмжээг тогтоосон шийдвэрийн төслийг бэлтгэсэн байна.

4.1.3. Ажлын хэсэг нь тухайн хуш модны самрын менежмент хариуцагч, ажлын хэсэг, ялагчтай байгуулах гэрээний төслийг танилцуулах.

4.2. Дуудлага худалдааны бэлтгэл ажлын зардлыг дуудлага худалдааны орлогоос гаргана.

#### **Тав. Дуудлага худалдааны зарыг зарлан мэдээлэх**

5.1. Дуудлага худалдааны зар (цаашид “зар” гэх)-ыг цахимаар дараах байдлаар нийтэд мэдээлнэ:

5.1.1. Сум дундын Ойн анги болон Бат-Өлзий сумын цахим хуудасаар;

5.1.2. Байгаль орчин газрын цахим хуудсаар;

5.2. Энэ удирдамжийн 5.1-д заасан зард дараах мэдээллийг заавал тусгана:

5.2.1. Дуудлага худалдаагаар үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх хуш модны самрын дээд хэмжээг, тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;

5.2.2. Дуудлага худалдааны хэлбэр;

5.2.3. Дуудлага худалдаа зохион байгуулах цахим хуудасны мэдээлэл (дуудлага худалдаа явуулах тусгай программ хангамж бүхий), харилцах утасны дугаар;

5.2.4. Дуудлага худалдаанд оруулах нутгийн нэр, болон батлагдсан дээд хэмжээ зэрэг мэдээллийг;

5.2.5. Дуудлага худалдааны босго үнэ;

5.2.6. Дэнчингийн хэмжээ, дэнчин тушаах дансны дугаар, дэнчин төлөх сүүлийн хугацаа;

5.2.7. Гэрээний зүйл;

5.2.8. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх хугацаа;

5.2.9. Дуудлага худалдаа эхлэх, дуусах он, сар, өдөр, цаг;

5.2.10. Дуудлага худалдаа зохион байгуулах аймаг, сум, баг, байр, тоот

5.2.11. Дуудлага худалдааны босго үнийг ёсгөх интервалийн хэмжээг зард зайлшгүй тусгана.

#### **Зургаа. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх**

6.1. Дуудлага худалдаанд оролцохыг хүссэн этгээд хүсэлтээ энэ удирдамжийн хавсралтад заасан маягтын дагуу үнэн зөв гаргаж uv.oin\_angi@ov.gov.mn цахим шуудангийн хаягаар тогтоосон хугацаанд илгээсэн байна.

6.2. Дуудлага худалдаанд оролцогч дуудлага худалдаанд оролцох хүсэлтдээ дараах материалыг хавсаргаж, цахимаар илгээнэ.

6.3 Хуулийн этгээдийн төлөөлж оролцох тохиолдолд төлөөлж буй этгээдийг гэрчлэх нотариатаар батлуулсан итгэмжлэл, Хуулийн этгээд улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, Ойн мэргэжлийн байгууллагын гэрчилгээний хуулбар;

6.4 Дэнчин төлсөн баримтын хуулбар;

6.5 Ажлын хэсэг хүсэлтийг хүлээн авч, дуудлага худалдааны оролцогч болсныг цахим дуудлага худалдаа явуулах тусгай программ хангамжид нэвтрэх нэр, нууц үгээр баталгаажуулж оролцогчид мэдэгдэнэ;

6.6 Дуудлага худалдаа явуулах ажлын хэсэг дуудлага худалдаанд оролцогчдын материалыг дуудлага худалдаа явуулахаас өмнө хааж, дуудлага худалдаа эхлэх цаг болмогц оролцогчдод бичиг баримтын үнэн зөв эсэх болон дэнчин төлсөн байдлыг шалгаж, ирсэн хүсэлтуүдийг оролцогч тус бүрээр нь ялган тавьж бүртгэнэ.

6.7 Бүртгэлийн материалаас ташаа мэдээлэл илэрсэн, эсхүл тухайн дуудлага худалдаанд оролцох хүсэлт биш тохиолдолд холбогдох этгээдийг дуудлага худалдаанд оролцуулахгүй. Энэ талаар тэмдэглэлд бүртгэнэ.

6.8 Дуудлага худалдаанд оролцогчдын бүртгэл, мэдээллийг дуудлага худалдааг нээх хүртэлх хугацаанд нууцалж, бусдад энэ талаар мэдээлэл өгөхийг хориглоно.

### **Долоо. Дуудлага худалдаа явуулах**

7.1. Сумын Засаг дарга дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийг байгуулж, дуудлага худалдааг ажлын хэсэг зохион байгуулна.

7.2. Дуудлага худалдаа явуулах ажлын хэсэг нь дарга, нарийн бичиг дуудлага худалдааны хөтлөгч (зарлагч), гэсэн үүрэг бүхий энэ удирдамжийн 1.3-т заасан бүрэлдэхүүнтэй байна.

7.3. Дуудлага худалдааны явцад үүссэн маргааныг тухайн дуудлага худалдаа явуулах ажлын хэсэг хянан шийдвэрлэнэ.

7.4. Дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийн дарга дор дурдсан эрх, үүрэгтэй.

7.4.1. Дуудлага худалдаа явуулах ажлыг бүрэн хариуцах;

7.4.2. Дуудлага худалдаа явуулахад зөвлөх ажилтныг сонгон ажиллуулах;

7.4.3. Дуудлага худалдааны явцын тэмдэглэл, дуу, дүрсний бичлэгийг;

үнэн зөв, бүрэн хөтлөгдсөн эсэхийг хянаж баталгаажуулан, дуудлага худалдаанд оролцогчид болон зохион байгуулагч талын төлөөлөл тэмдэглэлд гарын үсгийг цахимаар зурах;

7.5. Дуудлага худалдааны хөтлөгч дор дурдсан эрх, үүрэгтэй:

7.5.1. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэж, хувийн дугаар олгох;

7.5.2. Дуудлага худалдааг товлосон хугацаанд нь эхлүүлэх;

7.5.3. Үнэ хаялцуулах дэгийн дарааллын талаар болон өсгөн хэлэх үнийн хэмжээг зарлаж танилцуулах;

7.5.4. Дуудлага худалдааны явцын тэмдэглэлийг үнэн зөв, бүрэн хөтлүүлэх.

7.6. Дуудлага худалдааны нарийн бичиг дор дурдсан эрх, үүрэгтэй:

7.6.1. Дуудлага худалдааны явцын тэмдэглэлийг үнэн зөв, бүрэн хөтлөх;

7.6.2. Дуудлага худалдааны явцын тэмдэглэлд оролцогчдоор цахим гарын үсэг зуруулах.

7.6.3. Дуудлага худалдааг товлосон хугацаанд оролцогчдыг цахим хаягт оролцохыг утсаар холбогдож урих, оролцогч 2 дахь удаагаа урихад орж ирээгүй тохиолдолд түүнийг дуудлага худалдаанд оролцохос татгалзсанд тооцож, энэ тухай тэмдэглэлд тусгана;

7.6.4. Бүртгэлийн ажиллагаа дууссаны дараа дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийн дарга оролцогчдод тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа явуулах захирамж, түүнтэй адилтгах шийдвэрийг уншиж сонсгоно;

7.6.5. Дуудлага худалдаа явуулах ажлын хэсэг оролцогчдын материалыг шалгасны дараа энэ удирдамжийн 7.5.1-д заасан дугаарыг хуваарилж олгоно;

7.6.6. Хөтлөгч оролцогчдод дуудлага худалдааны журам болон үнэ хаялцуулах дэг, анхааруулах бусад зүйлийг танилцуулна;

7.6.7. Хөтлөгч дуудлага худалдаанд явуулах цахим зохион байгуулалтыг танилцуулж, дуудлага худалдааны өсгөн хэлэх үнийн хэмжээг зарлан, дуудлага худалдаа эхлүүлнэ

7.6.8. Өсгөн хэлэх үнийн дүнг босго үнээс 30 хувиас хэтрэхгүй.

7.6.9. оролцогч үнийн санал хэлэхэд хөтлөгч тухайн үнийн саналыг 3 удаа давтаж хэлнэ;

7.6.10.Дуудлага худалдаанд оролцогчид болон зохион байгуулагч талын төлөөлөл тэмдэглэлд гарын үсэг зурна.

7.7.1.Цахим дуудлага худалдааг товлосон өдрийн цаг, минут, секундэд эхлүүлж, мөн өдрийн цаг, минут, секундэд зогсоон;

7.7.2.Энэ удирдамжийн 7.7.1-д заасан хугацаанд хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн оролцогчийг дуудлага худалдаа явуулах программ хангамж ашиглан ялагчаар тодруулна;

7.7.3.Дуудлага худалдааны ялсан үнийг 72 цагийн дотор холбогдох дансанд бүрэн төлсний дараа зохион байгуулагч ялагчийг баталгаажуулсан шийдвэр гарна. Иргэний хуулийн 197 дугаар зүйлд заасны дагуу гэрээ байгуулах үүрэгтэй;

7.7.4. Цахим худалдааг заасан хугацаанд зогсоосноор оролцогчдоос ирүүлсэн үнийн санал тус бүрийн хугацааг цаг, минутаар бүртгэн тэмдэглэлд тусгана.

7.7.5.Дуудлага худалдааны ялагчаас бусад оролцогчдын дэнчинг ажлын 3 өдөрт багтаан буцаан шилжүүлэх бөгөөд шилжүүлэх данс тодорхойгүй тохиолдолд цахим бүртгэл дэх утас, хаягаар оролцогчтой холбогдож шилжүүлнэ;

### **Найм. Дуудлага худалдааг дахин явуулах**

8.1.Дараах тохиолдолд дуудлага худалдааг дахин явуулна:

8.1.1.Дуудлага худалдааны ялагч дуудлага худалдаагаар худалдан авсан хуш модны самрыг бэлтгэх ойн нөөц ашигласны төлбөр, дуудлага худалдааны дэнчингийн төлбөр, үнийг энэ удирдамжийн 7.7.3-т заасан хугацаанд бүрэн төлөөгүй, эсхүл төлөхийг зөвшөөрөөгүй тохиолдолд;

8.1.2.Дуудлага худалдаа явагдаагүй болон явуулах нөхцөл бүрдээгүй;

8.1.3.Дуудлага худалдааг хууль зөрчин явуулсныг шүүхийн шийдвэрээр тогтоосон;

8.1.4. Хуульд заасан бусад тохиолдолд.

8.2. Дуудлага худалдааг дахин явуулах шийдвэрийг Сумын Засаг дарга гаргах бөгөөд дуудлага худалдааны зарыг дахин дуудлага худалдаа явуулах өдрөөс хуанлийн 5-аас доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.

8.3. Дуудлага худалдааг дахин явуулахдаа энэ удирдамжийг мөрдөнө.

8.4. Энэ удирдамжийн 8.1-д заасан дуудлага худалдаанд 1 оролцогч оролцох хүсэлт гаргасан тохиолдолд дуудлага худалдааны анхны үнэ дээр өсгөн хэлэх үнийн доод хэмжээг нэмж, дуудлага худалдаагаар худалдан авах үнийг тогтоох бөгөөд тухайн оролцогч зөвшөөрвэл түүнийг дуудлага худалдааны ялагч гэж үзнэ.

### **Ес. Дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулах**

9.1.Дуудлага худалдаа ялсан үнийг 72 цагийн дотор холбогдох дансанд бүрэн төлсний дараа зохион байгуулагч ялагчийг баталгаажуулсан шийдвэр гарч ялагчтай гурвалсан гэрээ байгуулна.

9.2.Дуудлага худалдааны ялагч энэ удирдамжийн 9.1-т заасан дуудлага худалдааны гэрээнд туссан үнийг бүрэн төлнө.

9.3.Дуудлага худалдааны ялагч энэ журмын 9.2-т заасан хугацаанд дуудлага худалдааны дэнчин төлсөн төлбөр, ойн нөөц ашигласны төлбөр, улсын тэмдэгтийн хураамжийг бүрэн төлснөөр Сумын Засаг дарга энэ удирдамжийн 9.1 дэхь гэрээ, өргөдлийг үндэслэн үйлдвэрлэлийн зориулалтаар хуш модны самрыг бэлтгэх, зөвшөөрлийг гаргана.

### **Арав. Дуудлага худалдааны үнэ, дэнчин**

10.1. Дуудлага худалдааны анхны үнийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын баталсан ойн дагалт баялгийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээний 50 хувиар тооцно дуудлага худалдааны анхны үнийн санал гэж тооцно. баталсан үнийг баримтлана.

10.2. Дэнчинг Дуудлага худалдаанд оролцогч нь дуудлага худалдаа эхлэх босго үнийн 10 хувьтай тэнцэх хэмжээний дэнчинг дуудлага худалдаа эхлэхээс 24 цагийн өмнө холбогдох дансанд байршуулна.

10.3. Дуудлага худалдааны ялагчаас бусад оролцогчдын дэнчинг дуудлага худалдаа болсон өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор аливаа шимтгэлгүйгээр буцаан олгоно.

#### **Арван нэг. Дуудлага худалдааны орлогыг тайлагнах, зарцуулах**

11.1.Дуудлага худалдаанаас Бат-Өлзий сумын Төрийн сангийн 100100300914 дансанд орсон орлогын 50 хувийг Байгаль орчин уур амьсгалын дансанд шилжүүлэх үлдсэн 50 хувиас Сумын Засаг дарга дуудлага худалдааны орлогын 20-иос доошгүй хувийг дуудлага худалдаа зохион байгуулахад гарах зардал, нөөцийн судалгаа хийх, нөөцийг бэлтгэх талбай тусгаарлах, хяналт тавих зардалд зарцуулна.

11.2.Дуудлага худалдааны орлогоос дуудлага худалдаа зохион байгуулах бүх зардлыг шийднэ.

#### **Арван хоёр. Маргаан шийдвэрлэх**

13.1.Дуудлага худалдааны явцад үүссэн маргааныг дуудлага худалдаа явуулах ажлын хэсэг шийдвэрлэнэ.

13.2.Аж ахуйн нэгж, байгууллага дуудлага худалдаатай холбогдсон гомдлыг ажлын 3 өдөрт багтаан тухайн шатны Засаг дарга болон шүүхэд тавьж шийдвэрлүүлэх эрхтэй

--- oo ---

Сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар  
сарын 07-ны өдрийн А/195 дугаар  
захирамжийн гуравдугаар хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМААС ХУШ МОДНЫ  
САМАР ТҮҮЖ БЭЛТГЭХ БАГЦЫН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Багцын нэр	Багцын хэмжээ	Босго үнэ, төг	Дэнчингийн үнэ, төг
	1	2	3	4
1	Багц 01	20000	14,000.000	1,400.000
2	Багц 02	20000	14,000.000	1,400.000
3	Багц 03	30000	21,000.000	2,100.000
4	Багц 04	30000	21,000.000	2,100.000
5	Багц 05	48000	33,600.000	3,360.000
6	Багц 06	50000	35,000.000	3,500.000
7	Багц 07	74000	51,800.000	5,180.000
8	Багц 08	74000	51,800.000	5,180.000
9	Багц 09	147200	103,040.000	10,304.000
НИЙТ		493200	345,240.000	34,524.000

---оо---